

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ

Тус аймаг нь Монгол орны умард хэсэгт Орхон-Сэлэнгийн үзэсгэлэнт ойт хээрийн бүсэд 42.8 мянган кв.км газар нутгийг эзлэн оршдог. Зүүн талаараа Хэнтийн нуруу, баруун талаасаа Хангайн нурууны салбар болох Баянхан, Бүрэнхан, Бүтээл, Дулаанхан, Дэлгэрхан, Сонгоол зэрэг томоохон уул нуруудаар хүрээлэгдсэн. Цагаан, Гүн, Гялаан, Дангаа, Ишгэнт зэрэг нуур Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Зэлтэр, Хүдэр, Цөх, Шарын гол зэрэг том жижиг 86 гол мөрөнтэй.

Хүннүгийн үеийн хүн чулуун хөшөө, булш хирэгсүүр, их эзэн Чингис хааны домогт Буур хээрийн тал, сүсэгтэн олны бишрэл хүндлэл болсон бурхан номын ариун газар Амарбаясгалант хийд, Ардын хувьсгал газар тариалангийн өлгий нутаг гээд түүх, соёлын баялаг өв сантай. Аймгийн хэмжээнд байгалийн үзэсгэлэнт газар 43, түүх, соёлын дурсгалт газар 84, эмчилгээ сувилгаа, рашаан ус, эмийн ховор ургамалтай 11 газар байдаг. Монгол улсын ойн сангийн 12 хувь, урсгал усны 40 хувь, улсын болон орон нутгийн чанартай 1100 км автозам болон Сэлэнгэ аймгийн 7 сумын нутгаар Монгол-ОХУ хамтарсан Улаанбаатар төмөр зам дайран өнгөрдөг. Аймгийн нутаг дэвсгэрийн 9.3 хувийг Улсын болон орон нутгийн чанартай Тусгай Хамгаалалттай Газар Нутаг эзэлдэг гэх мэт аялал жуулчлал хөгжүүлэхэд таатай олон нөхцөл, нөөц боломжийг дурдаж болно. Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 20 гаруй жуулчны бааз, амралтын газар, 40 гаруй том, жижиг зочлох үйлчилгээний байгууллага жуулчдыг хүлээн авч, үйлчилж байна.

Сэлэнгэ аймагт дотоодын жуулчдын сэтгэлийг татдаг хэд хэдэн онцлог үзмэр бий тухайлбал Шаамар сумын “Ээж” мод хэмээх тахилгатай мод, Дулаанхаан уул, Алтанбулаг сумын Номтын ам “Далийн ягаан цэлцэг”, Буур хээрийн тал, Гүннуур, “Сайханы хөтөл”, Мандал сумын Ширхэнцэг уул, Ноён уул, Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд гээд багагүй урт жагсаалт гаргаж болно эдгээрийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд, хувийн хэвшлийнхний хүчин чармайлт оролцоо зайлшгүй хэрэгтэй байгаа бөгөөд орон нутгийн төр захиргааны зүгээс аялал жуулчлалыг хөгжүүлэх аливаа үүсгэл санал санаачлагыг дэмжиж, хамтран ажиллахад үргэлж нээлттэй байх болно.

### *Сэлэнгэ аймагт аялал жуулчлал хөгжүүлэх таатай орчин*

1. Орхон Сэлэнгийн бэлчир, Сайханы Хөтөл
2. Тужийн нарсны байгалийн цогцолборт газар
3. Хан-Хэнтийн дархан цаазат газар
4. Ардын журамт цэргийн түүхэн ялалтын ой, баатруудад зориулсан хөшөө дурсгалууд, дайчин алдрын замнал
5. Хараа гол, Ерөө, Зэлтэр зэрэг гол мөрөнд спорт загас агнуур хийх,
6. Ан агнуур /загас, чоно, бор гөрөөс, зэрлэг гахай гэх мэт/

7. Байгалийн дагалдах баялаг
8. Шашны болон бөө мөргөлийн аялал жуулчлал. Амарбаясгалант хийд, “Ээж мод”
9. Аймгийн наадам, цагаан сарын ёслол,
10. Урлаг, соёл, спортын олон улсын болон бүс нутгийн чанартай арга хэмжээнүүд
11. Нүүдэлчин Монгол үндэсний ёс заншил, ахуй амьдралтай танилцах г.м

#### *Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын стратегийн нөөцүүд*

1. “Эв” модны наадам
2. Таван “хаан” уулын тахилга
3. Амарбаясгалант хийд “Бумбаны баяр”, “Цам”
4. Ардын журамт цэргийн түүхэн замнал
5. Ургацын баяр
6. Алтанбулаг –Худалдааны чөлөөт бүс, хил орчмын аялал жуулчлал  
Алтанбулаг-Ардын хувьсгалын өлгий /Анхны түр Засгийн газрын байр, Консулын байр, анхны Банк, анхны Аптек.../
7. Хаврын ойжуулалт, “нэг мод-нэг иргэн” арга хэмжээ...
8. Усан аялал г.м

### **Соёл, спорт, аялал жуулчлалын газар**